



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/16

Мөрөн сум

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.14, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал, амьтныг халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн өвчний тархвар зүй, голомтын судалгаанд үндэслэн 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Ариунаа) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Мал сүргийг халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд голомт бүхий газар нутагт байгаа мал сүргийг бүрэн хамруулсан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, сумын Мал эмнэлгийн тасгийн байцаагч нарт хариуцуулсугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР